



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2021 оны 12 сарын 22 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

“Хорооны хуралдааны урамшууллын хэмжээ”-г шинэчлэн
тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор баталсан “Харилцаа холбооны зохицуулах хорооны дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.3.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Харилцаа холбооны зохицуулах хорооны хуралдааны урамшууллын нэг цагт олгох хэмжээг хорооны дарга, гишүүдэд 380 000 (гурван зуун наян мянга) төгрөгөөр шинэчлэн тогтоосугай.
2. Энэхүү тогтоолыг 2022 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.
3. Энэхүү тогтоол батлагдсантай холбогдуулан Харилцаа холбооны зохицуулах хорооны 2019 оны “Хорооны хуралдааны урамшууллын хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 34 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг тус Хорооны дарга /Г.Чинзориг/-д үүрэг болгосугай.

ДАРГА

Г.ЧИНЗОРИГ

ХОРООНЫ ХУРАЛДААНЫ
НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Т.НАРАНМАНДАХ